



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/53

Аргатай


Г Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай Г

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Шилийн гол 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт гарсан бог малын Мялзан өвчний шинж тэмдэг бүдгэрч эдгэрсэнтэй холбогдуулан 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс тогтоосон малын гоц халдварт бог малын "Мялзан" өвчний хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2.Сумын онцгой комиссоос шуурхай арга хэмжээ авч дээрх бүс нутагт хязгаарлалтын арга хэмжээ авч ажиллаж, халдвар тархаагүй өвчлөл дахин илрээгүй болохыг бүс нутаг дэвсгэрт нутаглаж буй малчдад мэдэгдсүгэй.

3.Малчдыг мэдээллээр хангаж, тухайн бүс нутаг дэвсгэрийн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, малын гоц халдварт "Мялзан" өвчнөөс сэрэмжилж ажиллах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэхийг багийн Засаг дарга нар, Мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт болон Мал эмнэлэгийн тасгийн тархвар зүйч их эмч (Ц.Батбилэг), малчин ард иргэдэд тус тус даалгасугай.

ДАРГА  УУГАНБААТАР

482701080